

Гепатит дельта – энгийнээр тайлбарлавал

Халдвараас сэргийлэх

Гепатит Д вирус нь цус (өндөр эрсдэлтэй) болон биеийн шингэнээр (бага эрсдэлтэй) дамжин халдварлана.

Гепатит Д болон Б вирусийн халдварлах зам ижил бөгөөд та өөрийгөө халдвараас сайн сэргийлж чадна.

Та халдварлах замыг мэдэж байгаа тохиолдолд урьдчилсан сэргийлэх боломжтой:

■ Гепатит Б вирусийн эсрэг вакцинжуулалт

Гепатит Б вирусийн эсрэг вакцин хийлгэсэн тохиолдолд гепатит Д-ийн халдвараас сэргийлдэг. Учир нь гепатит Д нь Б вирусийн халдвар авсан хүмүүст тохиолддог.

■ Жирэмсний үедээ халдвар авсан тохиолдолд эмчид мэдэгдэх

Эмч эхээс урагт халдвар дамжихаас сэргийлж хийсвэр хагалгаа хийх гэх мэт халдварлах эрсдэлийг бууруулах арга хэмжээг авдаг.

■ Цустай харьцахдаа ариутгалын нөхцөлийг баримтлах


- Цус алдалтыг эмчлэхдээ зориулалтын бээлий хэрэглэх
- Багаж хэрэгслийг хэрэглэхдээ эрүүл ахуйн байдлыг анхаарах хэрэгтэй. Энэ нь мөн шивээс, эмнэлгийн болон бие цоолох хэрэгсэлд хамааралтай. Бүх хэрэгслийг дахин ашиглахаас өмнө ариутгасан байх ёстой.

■ Хамгаалалттай бэлгийн харьцаа

Бэлгэвч хэрэглэх нь халдвар авахаас хамгийн найдвартай хамгаалалт болдог.

■ Ариун цэврийн хэрэгслийг хуваалцахгүй байх

Сахлаа хусах, шүдээ угаах нь бага зэргийн цус алдалт (буйлнаас цас гарах) үүсгэнэ. Эдгээр зүйлсийг хуваалцахгүй байх нь халдвар авах эрсдэлээс сэргийлнэ.



content liability:

Kautz⁵ gUG
Hauptstraße 335 · 51143 Köln
post@kautzhoch5.de · www.kautzhoch5.de



gemeinnützige Projekt- und
Beratungsgesellschaft für patientenzentrierte
Versorgungsforschung und Gesundheitskonzepte

in cooperation with:

World Hepatitis
Alliance

with kind support of:



MYR GmbH ist jetzt eine Tochtergesellschaft von Gilead Sciences, Inc.